



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах зарим  
арга хэмжээний тухай

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1, 8.4, 8.5, 19.1, 21, 47.4, 48.1, 49 дүгээр зүйлийн холбогдох заалтыг зөрчиж, 327.6 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Жаргалсайханд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2.2. Байгууллагад хөтлөгдөж буй албан баримт бичиг, гэрээ хэлцэл, холбогдох бусад эрх зүйн актыг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, зааврын дагуу боловсруулах, бүрдүүлэх, хадгалах;

2.3. Дээд байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллах.


2.4. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

  
Б.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

  
Ц.ТҮВШИНЗАЯА

000011


  
 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн  
 68. дугаарт тогтоолын хавсралт

**“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчийт хувьцаат  
 компанийд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг  
 арилгах арга хэмжээний жагсаалт**

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1. Худалдан авалт, гэрээ, хэлцэлтэй холбоотой зөрчил					
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин нээлттэй тендер шалгаруулалтын үнэлгээг журмын дагуу хийгээгүй, төлөвлөгөөг ил тод зарлаагүй, урьдчилгаа төлбөрийн баталгаагүй байхад урьдчилгаа төлбөр олгосон, харьцуулалтын арга хэрэглээгүй	2016-2017 он	327.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1.1, 8.4, 8.5, 19.1, 21, 47.2, 48.1, 49 дэх заалт	Хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, үнэлгээний хорооны гишүүдэд холбогдох арга хэмжээ авах.
	НИЙТ ДҮН:		327.6		